

Банкуудын зээлийн тайлан

2017 оны 4 дүгээр сар

Хураангуй мэдээлэл:

- Банкуудын **нийт зээлийн үлдэгдэл 2017 оны 4 дүгээр сарын байдлаар 12.6 их наяд төгрөгт хүрснээс 80.6 хувь нь төгрөгөөр олгогджээ.**
- Тайлант сард шинээр **1 их наяд төгрөгийн зээл олгогдсоны 80.2 хувь нь төгрөгийн зээл байна. Харин 959.6 тэрбум төгрөгийн зээл төлөгдөв.**
- Нийт зээлийн 8 хувийг хугацаа хэтэрсэн зээл, 8.6 хувийг чанаргүй зээл бүрдүүлж байна. Усан хангамж, ус, хог хаягдлын менежмент, цэвэрлэх байгууламжийн салбарын чанаргүй зээл 48.6 хувь, уул уурхайн салбарын чанаргүй зээл **30.2 хувь**, худалдааны салбарын чанаргүй зээл **14.8 хувь**, боловсруулах үйлдвэрийн чанаргүй зээл **13.5 хувьтай** байна. Харин нийт чанаргүй зээлийн **25 хувь** нь худалдаа, **20.9 хувь** нь уул уурхай, **16.6 хувь** нь боловсруулах салбарт тус тус ногдож байна.
- Нийт хэвийн зээлийн үлдэгдлийн 59 хувийг 1-5 жилийн хугацаатай зээл, 22 хувийг 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээл, 18.9 хувийг 1 жил хүртэлх зээл бүрдүүлж байна. Харин тухайн сард олгосон зээлийн **45 хувь нь 1 жил хүртэл, 45.4 хувь нь 1-5 жил, 9.6 хувь нь 5-аас дээш жилийн хугацаатай олгогджээ.**
- Нийт зээлийн үлдэгдлийн 52 хувийг хувийн хэвшилд, 47.2 хувийг иргэдэд олгосон зээл эзэлж байна. **Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 19.2 хувиар, хувийн хэвшилд олгосон зээл 3.9 хувиар тус тус өсчээ.**
- ЖДҮ эрхлэх зориулалтаар **44.1 мянган аж ахуйн нэгж болон иргэдэд нийт 2 их наяд төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй** байна. ЖДҮ эрхлэгчдийн зээлийн **ЖДХүү жилийн 19.5хувь, ЖДХугацаа 23.7 сар** байна. ЖДҮ-ийн зээлийн үлдэгдлийн **33.3 хувь нь худалдааны салбарт, 23.5 хувь нь боловсруулах үйлдвэрт, 9.3 хувь нь үйлчилгээний салбарт, 7.9 хувь нь барилгын салбарт олгогджээ.**


Нийт зээлийн үлдэгдэл өмнөх оноос 9.2 хувиар өсч 12 их наяд 621.8 тэрбум төгрөгт хүрчээ. Үүнээс *татан буугдсан*¹ банкуудын зээлийн үлдэгдлийг хасч тооцвол 12 их наяд 420 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос 9.7 хувиар өссөн үзүүлэлт юм. Харин *Ипотекийн зээлийн үлдэгдлийг* оруулж тооцвол нийт зээлийн үлдэгдэл 16 их наяд 738 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос 7.5 хувийн өсөлттэй байна.

Нийт зээлийн үлдэгдлийн 80.6 хувь төгрөгийн, 19.4 хувь валютаар олгогдсон зээл байна. Ихэнх салбаруудад төгрөгийн зээл түлхүү олгогдсон байна. Харин санхүү даатгал, боловсрол, цахилгаан, хий, уур, агааржуулалт хангамжийн салбарт валютын зээл давамгайлж байна.


Тайлант сард банкууд нийт 1 их наяд 14 тэрбум төгрөгийн зээл шинээр олгосон байна. Олгосон зээл өмнөх сараас 49.6 тэрбум төгрөгөөр буюу 5.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 4 дүгээр сарын байдлаар нийт 959.6 тэрбум төгрөгийн зээл төлөгдсөн бөгөөд өмнөх сараас 38.5 хувиар илүү байна.

Нийт зээлийн 83.5 хувь нь хугацаандаа байгаа зээл, 8 хувь нь анхаарал хандуулах зээл, 8.6 хувийг чанаргүй зээл тус бүр эзэлж байна.

Зураг 1. Зээлийн үлдэгдэл



Зураг 2. Зээлийн үлдэгдэл /төгрөг, валютаар/



Зураг 3. Олгосон, төлөгдсөн зээл



¹ Зоос, Хадгаламж банк.

Олгосон салбаруудаар нь авч үзвэл усан хангамж; бохир ус, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагааны салбарын чанаргүй зээл 48.6 хувь, уул уурхай олборлолт 30.2 хувь, худалдааны салбарынх 14.8 хувь, боловсруулах үйлдвэрийнх 13.5 хувьтай байгаа бол мэдээлэл, холбооны салбарын чанаргүй зээл 1.8 хувь, боловсролын салбарынх 1.9 хувь, цалин, тэтгэвэр хадгаламж барьцаалсан зээл 1.7 хувьтай байна.


Нийт чанаргүй зээлийн 25 хувийг бөөний болон жижиглэнгийн худалдаа, 20.9 хувийг уул уурхай олборлолт, 16.6 хувийг боловсруулах үйлдвэрлэлийн салбарт олгосон зээл бүрдүүлж байна.

Шинээр олгосон зээлийг салбаруудаар ангилан авч үзвэл 38.5 хувийг хэрэглээний зээлд, 22.8 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 6.4 хувийг боловсруулах үйлдвэрт, 5.5 хувийг орон сууцны ипотекийн зээлд тус тус олгожээ.


Тайлант сард нийт олгосон зээлийн 45 хувийг 1 жил хүртэл хугацаатай зээл, 45.3 хувийг 1-5 жил хүртэл хугацааны зээл, 9.6 хувийг 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай олгогджээ.

Харин нийт хэвийн зээлийн үлдэгдлийн 59 хувийг 1-5 жилийн хугацаатай зээл, 22 хувийг 5 ба түүнээс дээш жилийн хугацаатай зээл, 18.9 хувийг 1 жил хүртэлх зээл бүрдүүлж байна.


Зураг 4. Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь /салбараар/



Зураг 5. Олгосон зээл /салбараар/



Зураг 6. Олгосон зээл /хугацааны ангиллаар/



Чанаргүй зээлийн талаар өмнө дурдсан бөгөөд анхаарал хандуулах зээлийг гол гол салбаруудын авч үзвэл барилгын салбарын анхаарал хандуулах зээл 13.6 хувь, бөөний болон жижиглэн худалдааны салбар 6.3 хувь, боловсруулах үйлдвэр 5.8 хувь, хэрэглээний зээл 1.8 хувьтай байна.

Банкууд чанаргүй зээлээс үүдэж гарах алдагдлаас хэр хамгаалагдсан байгаа эсэхийг тодорхойлдог нөөцийн хүрэлцээний харьцаа (provision coverage ratio)-г салбар бүрээр авч үзвэл мэргэжлийн, шинжлэх ухаан, боловсрол, цахилгаан, захиргаа, уул уурхайн салбаруудын харьцаа хүрэлцээтэй түвшинд байгаа бол хүний эрүүл мэнд, усан хангамж, төрийн удирдлагын салбар дахь уг харьцаа бага байна.


Нийт зээлийн үлдэгдлийн 52 хувийг хувийн хэвшилд, 47.2 хувийг иргэдэд олгосон зээл эзэлж байна. Хувийн хэвшилд олгосон зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 3.9 хувиар өсжээ.

Хувийн хэвшлийн зээлийн үлдэгдлийн 21.9 хувийг бөөний болон худалдааны салбарт, 19 хувийг боловсруулах үйлдвэрт, 17.5 хувийг барилгын салбарт, 11 хувийг уул уурхай олборлолтын салбарт ногдож байна.


Зураг 7. Чанаргүй зээл, хугацаа хэтэрсэн зээл /тухайн салбартаа эзлэх хувиар/



Зураг 8. Нийт зээлд эзлэх эрсдэлийн сан ба чанаргүй зээлийн харьцаа



Зураг 9. Хувийн байгууллагын зээлийн үлдэгдэл



Иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 19.2 хувиар нэмэгдсэн байна.


Харин МИК-д шилжүүлсэн зээлийн багцыг оруулж тооцвол иргэдийн зээл өмнөх оны мөн үеэс 16.8 хувиар хувиар өсжээ.

Тайлант сард олгосон нийт жигнэсэн дундаж хүү жилийн 19.7 хувьтай байгаа бол салбараар авч үзвэл уул уурхай 22.5 хувь, барилга 21 хувь, хэрэглээний зээл 20.2 хувь, бөөний болон жижиглэн худалдаа 19.3 хувь, хөдөө аж ахуй 19.2 хувь, боловсруулах үйлдвэр 18.6 хувь, тээвэр агуулах 17.2 хувь байна.

Үл хөдлөх хөрөнгийн салбарт олгосон зээлийн хүү харьцангуй бага жилийн 11.3 хувьтай байгаа нь тус салбарт ипотекийн зээл ордогтой холбоотой байна.


Тухайн сард иргэдийн зээл 5 их наяд 958 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байгаагийн 30.9 хувь буюу 1 их наяд 842 тэрбум төгрөг ипотекийн, 28.7 хувь буюу 1 их наяд 715 тэрбум төгрөг цалингийн, 11.9 хувь буюу 713 тэрбум төгрөг бусад зээлд, 12 хувь буюу 713.6 тэрбум төгрөг жижиг дунд үйлдвэрийн, 10.6 хувь буюу 633 тэрбум төгрөг тэтгэврийн, 5.7 хувь буюу 340 тэрбум төгрөг хэрэглээний зээл байна.

Зураг 10. Иргэд, хувийн хэвшилд олгосон зээлийн жилийн өсөлт




Зураг 11. Олгосон зээлийн жилийн хүү /салбараар/

◆ Дээд хүү ◆ Доод хүү ◆ Жигнэсэн дундаж хүү



Зураг 12. Иргэдийн зээл /зориулалтаар/




Нийт иргэдийн зээлийн үлдэгдлийн 3.6 хувийг чанаргүй зээл эзэлж байна.

Харин иргэдийн ипотекийн зээлийн 3 хувь, цалингийн зээлийн 2 хувь, бусад зээлийг 3.1 хувь, хэрэглээний зээлийн 1 хувь, тэтгэврийн зээлийн 3 хувь нь чанаргүй зээл байна.

Тайлант сард иргэдэд олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү жилийн 19.6 хувь, цалингийн зээл 20.2 хувь, хэрэглээний зээл 19.7 хувь, бусад зээл 21.7 хувь, тэтгэврийн зээл 17.8 хувьтай байна. Харин хугацаагаар нь авч үзвэл ипотекийн зээлийн дундаж хугацаа 18.2 жил, цалингийн зээл 3 жил, бусад зээл 2 жил, хэрэглээний зээл 1.4 жил, тэтгэврийн зээлийн хугацаа 6.1 сарын хугацаатай байна.

Тайлант сарын эцсийн байдлаар ЖДҮ эрхлэх зориулалтаар аж ахуйн нэгж болон иргэдэд нийт 2 их наяд 41 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. ЖДҮ эрхлэх зориулалтаар ААН-д олгосон зээлийн үлдэгдлээс хамгийн өндөр 33.5 хувь буюу 444.3 тэрбум төгрөгийн зээлийг боловсруулах үйлдвэрт, 23.8 хувь буюу 316.6 тэрбум төгрөгийг худалдааны салбарт олгожээ. Харин ЖДҮ эрхлэх зориулалтаар иргэдэд олгосон зээлийн бөөний болон жижиглэн худалдааны салбарт хамгийн өндөр хувь 50.9 буюу 363 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.


Зураг 13. Иргэдийн чанаргүй зээлийн хувь /зориулалтаар/



Хүснэгт 1. Иргэдийн зээлийн жигнэсэн дундаж хугацаа

	Зээлийн дундаж хүү /хувь/	Зээлийн дундаж хугацаа /сар/
Ипотекийн зээл	10.5	218.9
Хэрэглээний зээл	19.7	16.9
Цалингийн зээл	20.2	36.2
Тэтгэврийн зээл	17.75	7.3
Бусад зээл	18.3	25.3


Зураг 14. ЖДҮ-ийн зээл /олгосон салбараар/



ЖДҮ-ийн зориулалтаар олгосон нийт зээлийн үлдэгдлийн 14.2 хувь чанаргүй зээл болжээ. Салбараар нь авч үзвэл ЖДҮ-ийн зориулалтаар аж ахуйн нэгжид олгосон зээлийн хувьд бөөний болон жижиглэн худалдааны салбарт 27.9 хувь, иргэдэд олгосон зээлийн хувьд барилгын салбарт чанаргүй зээл мөн адил өндөр 28.6 хувьтай байгаа нь чанаргүй зээл өндөртэй салбарт орж байна..

Банкууд 2017 оны 4 дүгээр сард ЖДҮ эрхлэгчдэд дунджаар жилийн 19.5 хувийн хүүтэй, 23.7 сарын хугацаатай зээлийг олгосон байна. Иргэдийн хувьд ААН-үүдтэй харьцуулахад зээлийн хүү өндөр, хугацаа урттайгаар зээл авсан байхад ААН-үүдийн зээлийн хүү харьцангуй бага хүүтэй, хугацаа богино зээл байна. Тодруулбал ЖДҮ эрхлэгч иргэдийн зээлийн ЖДХүү жилийн 21.7 хувь, хугацаа 31.1 сар, ААН-ийн ЖДХүү жилийн 17.6 хувь, хугацаа 17.3 сар байна.

Зураг 15. ЖДҮ-ийн чанаргүй зээлийн хувь



Зураг 16. ЖДҮ-ийн зээлийн хүү, хугацаа

